

МОНГОЛЫН БУДДЫН ШАШНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ.

Д.Наранцацрал. ШУТИС.ХүУС. ахлах багш, доктор /Ph.D/

Түлхүүр үг: Буддын шашин, шашны байгууллага, сүм хийдүүд, уламжлалт шашин, өөрчлөлт шинэчлэлт

Хураангуй

Аливаа шашин тухайн улс үндэстний соёл уламжлал, зан заншил, уламжлалыг өөртөө гүнзгий шингээж, нэг үеэс нөгөө үед дамжуулдаг соёлын гол тээгч болдог. Энэ нь Монголчуудын хувьд Буддын шашин юм. Өөрөөр хэлбэл, Бурханы шашнаар дамжуулан бид өөрсдийн соёл уламжлалаа хадгалан үлдэх явдал манай соёл иргэншлийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Ийм үед Монголын шашны амьдралд гарч буй шинэ нөхцөл, байдлыг анхааран авч өөрсдийн уламжлалт шашнаа хэрхэн авч үлдэх вэ, хэрхэн сүсэгтэн олны дундах байр суурийг хуучин хэвээр хадгалах вэ, чухам ямар үйл ажиллагаа явуулах нь энэ үйл явцад эерэг нөлөө үзүүлэх вэ зэрэг асуудлууд чухлаар тавигдах болж байна.

Аль ч улс оронд шашин шүтлэг бол тухайн ард түмний оюун санааны амьдрал, соёл иргэншлийн онцлогийг нь тодорхойлдог нэг гол элемент болдогоос гадна ард иргэдийн амьдралд, сүсэг бишрэлийг төрүүлж өөр хүчинд итгэх итгэлийг бий болгодог нэгэн том салбар шинжлэх ухаан юм.

Манай улсын хувьд дээр үеэс нүүдэлчин монголчууд хэмээн тодотгол зүүж явсаар эдүгээ суурин соёл иргэншилд шилжиж, олон шашны урсгал чиглэл орж ирсэнээр нийгэмд эерэг сөрөг үзэгдлүүд ихээр гарах болсон. Тухайлбал монгол улсад үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагын /сүм хийдийн / тоог хүснэгтээр харуулбал¹:

Аймаг нийслэл	Сүм хийдийн тоо									
	Бүгд		Будда		Христ		Ислам		Бусад	
	2003	2004	2003	2004	2003	2004	2003	2004	2003	2004
Бүгд	214	225	150	137	39	63	22	22	3	3

Дээрх тооноос харахад нэг жилийн дотор Христийн сүмийн тоо 24 /61.5хувь/ - өөр нэмэгдэж Буддын сүмийн тоо 13 /8.6 хувь/ -аар буурч байна.

¹ Эх сурвалж : УСГ, Статистикийн эмхэтгэл. 2004 он

Өөрөөр хэлбэл Христийн сүмүүдийн тоо гурав дахин өсчээ. Бас нэг жишээ дурдъя¹.

Аймаг нийслэл	Сүм хийдэд ажиллагсдын тоо									
	Бүгд		Будда		Христ		Ислам		Бусад	
	2003	2004	2003	2004	2003	2004	2003	2004	2003	2004
Бүгд	3946	4087	3173	3008	311	971	427	82	35	26

Дээрх тоо мэдээнээс харахад шашны байгууллагад ажиллагсдын тоо ч огцом өсөж, нэг жилийн дотор гурав дахин нэмэгдсэн байдал харагдаж байна.

Хүн бүр шашин шүтэх, эс шүтэх эрхтэй ч, Монгол улсад Христийн шашин шүтэгчдийн тоо ингэж их нэмэгдэв үү, эсвэл өөр шалтгаан байна уу гэдэг нь анхаарал татаж байна.

"XXI зууны монгол дахь шашин шүтлэг ба үндэсний аюулгүй байдал" сэдэвт социологийн судалгаагаар

Он	Гүн сүсэгтэн	Сүсэгтэн	Хэлбэлзэгч	Шашны бус байр суурьтай	Тууштай шашингүйн үзэлтэн
1994	6.8%	36.8%	28.6%	20.2%	7.0%
2003	3.91%	61.15%	14.4%	11.33%	6.75%

Эндээс үзвэл өнгөрсөн арваад жигд шашин хийгээд шашингүй байр суурийн талаархи манай хүмүүсийн үзэл бодол нэлээдгүй жигдэрч төлөвших хандлагатай болжээ гэж үзэж болохоор байдал ажиглагдаж байна. Шашингүйн үзэл санааг тууштай баримталдаг /үзэл бодол нь төлөвшиж тогтсон/ хүмүүсийн тоо хэмжээ үндсэндээ тогтвортой /7.0%-6.75%/ хэвээрээ байхад 10 жилийн өмнө үндсэндээ 3 хүн тутмын 1 нь хэлбэлзэгч букуу байр суурь нь тодорхойгүй байж, бас 5 хүн тутмын 1 нь үзэл бодол байр суурийн хувьд ерөнхийдөө шашингүй талдаа, гэхдээ тэр нь баттай бүрэн итгэл үнэмшил болон төлөвшиж хараахан завдаагүй тийм хүмүүс байсан бол өнөөдөр эдгээр үзүүлэлт тус бүр бараг 1 дахин багасаж /28.6%-14.4%, 20.2%-11.33%/ тэр хэмжээгээр сүсэгтний тоо нэмэгдсэн, гэхдээ гүн сүсэгтний тоо бараг 1 дахин буурсан дүн гарч байна.

Ер нь шинэ шашнууд сурталчилгаандаа радио, телевиз зэрэг нийтийн мэдээллийн хэрэгслийг өргөн ашигладаг, сурталчилгааны тараах материал ихээхэн түгээдэг, нийгмийн эмзэг хэсэг бүлгийнхэнд хүрч ажиллах талаар ихээхэн анхаардаг зэрэг бурханы шашны сүм хийдүүдээс менежментийн хувьд үлэмж давуутай идэвхитэй ажиллаж байгаа байдал аргагүй үр дүнгээ өгч нөлөөлж байгаа нь энд харагдаж байна.

Монголд шинээр орж ирж буй шашнуудын тухай мэдээлэлийг та хаанаас голчлон авдаг вэ гэсэн асуултанд хариулсан хүмүүсийн 52.5% нь радио, телевиз, сонин хэвлэл, ном зохиолоос гэсэн хариулт сонгожээ. Үүнээс гадна хоёр дахь гол зам суваг бол цуглаанд буюу сүмд очиж үзсэн явдал гэнэ.

¹ Эх сурвалж : ҮСГ, Статистикийн эмхэтгэл. 2004 он

Сурталчилгааны арга барил, хэлбэрээрээ уламжлалт бус шашнууд нь уламжлалт шашнаасаа хавьгүй илүүтэй гэсэн дүгнэлтийг эндээс хийж болох байна. Харин уламжлалт шашнуудын тухайд бол тэд менежмент, үйл ажиллагааны арга хэлбэрээрээ гэхээсээ илүүтэйгээр чухамхүү "уламжлалт" гэдэг утгаараа л хүн амын дунд жин дарж нөлөөлсөөр байна. Тэгвэл уламжлалт шашиндаа өнөөдөр монголчууд сэтгэл хангалуун байна уу өөрөөр хэлбэл эдгээр шашныхаа талаар ямар үзэл бодол дүгнэлттэй байдаг вэ гэдэг бол бас анхаарч үзмээр асуудал юм.

Судалгааны дүнгээс үзэхэд 60 орчим хувь нь энэ шашнаа хэвээр байлгах ёстой гэсэн ба үлдсэн хувь нь түүнийг зайлшгүй шинэчлэгдэх шаардлагатай гэж үзжээ.


Уламжлалт шашиндаа шинэтгэл хийхийг 51.6% нь дэмжиж байгаа илэрхийлжээ. Уламжлалт шашиндаа шинэтгэл хийх талаар ярихад манай лам нар уламжлалт шашныг яаж өөрчлөх вэ гэж таагүй ханддаг байна. Тэгвэл энд давхар хэлэхэд ном сургаалдаа шинэтгэл хийх бус зөвхөн үйл ажиллагааны арга хэлбэрт нь сүсэгтэн хийгээд нийт нийгэм орчиндоо хүрч үйлчилж буй байдалд нь шинэчлэл өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзэж байна.

Олон арван шинэ шашин орж ирсэнээр манай оронд


Эдийн засгийн хөгжил дэвшилд муугаар нөлөөлнө гэж	22.49%
Үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолд сөрөг нөлөөтэй гэж	46.97%
Монгол зан заншил, соёл уламжлалд муугаар нөлөөлнө гэж	45.11%

тус тус үзсэн байхад эл бүх үйл явц хүмүүсийн мэдлэг боловсрол, соёлд эерэг нөлөөтэй гэж 23.51% нь, гадаад харилцаанд сайнаар нөлөөлнө гэж 17.44% нь, нөлөөлөхгүй гэж 16.67% нь хариулсан байна.

Авсан судалгаанаас харахад та ямар шашин шүтдэг вэ гэсэн асуултанд доорх байдлаар хариулсаныг графикаар харуулъя.



дээрхээс харахад буддын шашинг хамгийн их хувь буюу 65.5% нь шүтдэг гэсэн хариулт өгч байгаа ч уламжлалт гэдэг утгаараа ихээхэн жин дарж, дийлэнх нь ингэж хариулж байгаа боловч судалгаанд оролцогчид шашны байгууллага нь бусдын сайн сайхны төлөө л ном хурдаг гэж үзсэн байх нь буддын шашны байгууллага нь явуулж буй үйл ажиллагаандаа анхаарч шинэлэг санаа гарган бусад байгууллага болон нийгмийн үйлчилгээний байгууллагатай хамтарч ажиллавал ард иргэд болон үйлчлүүлэгчид сэтгэл хангалуун байх болов уу.



Та шашны байгууллагын үйл ажиллагааг юу гэж боддог вэ?

Асуулт	Хүний тоо	Хувь
Нийгэмд зайлшгүй байх шаардлагатай	26	42.6%
Бусдын сайн сайхны төлөө	30	49.1%
Буян ном айлддаг	4	6.5%
Нийгмийн эмзэг бүлгийнхэнд тусладаг	0	0
Заавал байх шаардлагагүй	1	1.6%
Мэдэхгүй	0	0
Бусад	0	0

49.6% нь бусдын сайн сайхны төлөө гэж хариулсан нь хүмүүс зөвхөн ном хурж, сайн сайхны төлөө л шашны байгууллага байдаг гэж бодож байгаа нь харагдаж байна.

Бусад шашны газруудын үйл ажиллагаа нь нийгмийн эмзэг гэсэн хэсэг бүлгийг хамарч, сургалт сурталчилгаа, хоол унд, гутал хувцас, чөлөөт цагийг нь өнгөрөөх тусгай өрөө хүртэл гаргаж өгч байгаа нь иргэдийг татах чадвар болон санхүүжилт сайн хийгдэж байгаа нь амьдрал дээр ажиглагдсан.


Сургаал номлолоо илүү чөлөөтэй илэрхийлж гаргадаг учир үйлчлүүлэгчдийн чөлөөт цагт тохируулан шашны үйл ажиллагаагаа явуулж байхад, буддын шашин нь ард иргэдийн /үйлчлүүлэгчдийн/ цагийг үрж, дагаж мөрдөх зан заншил их байдаг учир иргэд тэр болгон ганданд очиж үйлчлүүлж чаддаггүй байна.

Дүгнэлт

Монголын буддын шашны байгууллагуудын олон нийтэд хандсан үйл ажиллагааг идэвхжүүлэхэд дараах хэдэн саналыг дэвшүүлж байна. Олон нийтийг сүм хийдийн үйл ажиллагаанд татан оролцуулах тэдний зүгээс

дэмжлэгийг олж авах эсэх нь цаашид нэлээн нарийн алсын хараатай бодлого, төлөвлөсөн үйл ажиллагааг шаардаж байгаа юм. Энд нэгэн судалгааг дурдъя:

■ Сүсэгтний өсөлт



Өнөөгийн нийгэмд гарч буй шашны үзэгдлүүд дээр тулгуурлан хийж гүйцэтгэж болох арга замыг сэдсэнээ сийрүүлэхийг хичээе.

- сүм хийд нь дотоод зохион байгуулалтын хувьд боловсронгуй болох. /Хурал номын нарийн тогтсон дэг ёсыг чандлан барьж дадах, зиндаа дээгүүр, ахмад лам нараа хүндэтгэх, сахилга батаас эхлэх/
- лам нарын боловсролын асуудлыг нэн даруй авч хэлэлцэн, залуу чадварлаг боловсон хүчнийг бэлтгэн гаргах, тэдгээр нь бусад лам болон сүсэгтнүүдийг шаардлагатай мэдээллээр цаг алдалгүй хангаж байх
- нэг зүйлд баригдалгүй янз бүрийн аргаар сүсэгтэн олон нийттэйгээ харилцах үйл ажиллагаагаа явуулах
- томоохон зан үйлүүдийг сүсэгтэн олны хамтаар байнга тогтмол явуулж олныг хамарсан үйл ажиллагааг явуулж байх, үүн дээр сүм хийдийн бус шашны байгууллагуудтай хамтарч ажиллах
- эцэст нь энэ бүхнийг зохицуулж байх бодлого төлөвлөлт, хяналтын албыг бий болговол үр дүнгээ богино хугацаанд өгөх болов уу хэмээн дээрх саналыг дэвшүүлж байна.

Ном зүй

1. Н.Багабанди "Шинэ цаг үе ба Монголын бурхан шашны өмнөх шинэ зорилт" УБ, 2001 он;
2. Д.Дагвадорж "Бурхан шашин, монгол уламжлал" УБ, 2002 он;
3. С.Цэдэндамба "Монгол Улс дахь шашны нөхцөл байдал ХХ-ХХI зууны зааг үе" УБ, 2003 он;
4. ҮСГ.Статистикийн эмхэтгэл. УБ., 2004.
5. "ХХI зууны Монгол дахь үндэсний аюулгүй байдал". Социологийн судалгаа. Интернэтийн эх сурвалж . <http://www.parl.gov.mn>